



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2018.06.26

Сүхбаатар сум

Монгол Улсын Засгийн газраас зарласан “Хариуцлагын жил”, аймгийн Засаг даргын 2016 оны “Ажлын хариуцлага, ажлын цаг ашиглалтыг сайжруулж, төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 05 дугаар албан даалгаварыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс 2018 онд “Хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлж, сахилга хариуцлагыг дээшлүүлэх” жил бодлогын зорилт дэвшүүлж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2018 оны хагас жилийн үйл ажиллагааг Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 126 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажил дүгнэх үзүүлэлт”-ийн дагуу дараах байдлаар тайлагнаж байна.

Нэг.Салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтийг зохион байгуулсан ажил үр дүн:

“Сэлэнгэ аймгийн Тогтвортой хөгжлийн зорилт-2030” бодлогын баримт бичгийн төслийг боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болоод байна. Тус бодлогын баримт бичгийн “Засаглалын бодлого”-ын бүлэгт хүний нөөцийн холбогдолтой зорилт арга хэмжээг тодорхойлон тусгаад байна.

Стратегийн зорилго, зорилтуудын хэрэгжилтийг хангах ажлыг жил бүрийн үйл ажиллагааныхаа төлөвлөгөөндөө тусгаж, төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг хангах, нутгийн захиргааны байгууллагын хүний нөөцийн удирдлагын чадавхийг хөгжүүлэх, төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг хангуулахад мэргэшил, арга зүйн зөвлөгөө дэмжлэгээр ханган ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн хөгжлийн хөтөлбөрийн тэргүүлэх зорилт, аймгийн Засаг даргын Тамгын газрын стратегийн зураглалын “Мэргэшсэн чадварлаг төрийн байгууллага” болох үндсэн зорилтыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаатай уялдуулан жил бүрийн үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг тодотгон боловсруулж, хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэсэн, хөгжлийн өөрчлөлт, нөхцөл байдалд уян хатан ханддаг, идэвхтэй, санаачлагатай, ёс зүйтэй бөгөөд манлайлагч төрийн албан хаагч, суралцагч байгууллага бүхий төрийн албыг орон нутагт төлөвшүүлэх зорилгоор 2018-2022 он хүртэл хэрэгжүүлэх **“Суралцагч байгууллага-Төрийн албаны манлайлал”** аймгийн



Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6.1, Хөдөлмөр бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.6 дахь заагийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд ТОГТООХ нь:

1.Суралцагч байгууллага-Төрийн албаны манлайлал аймгийн хөтөлбөр-ийг хэрэгжүүлж байгаагаар;

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлж арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, нэгдсэн удирдлагаар хэргийн хөтөлбөрийн биелэлтийн нөхцөл 2 жил тутамд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд төлөвлөгөөгөө амжилтын ажилын Засаг дарга АШ.Орчинг-а дэвтгээсэй.

ДАРГА Г.СЭЛЭНГЭ



хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг эхлүүлээд байна.

Төрийн зорилт чиг үүргийг чанартай, шуурхай хэрэгжүүлэх үүднээс төрийн албан хаагчийн ажиллах таатай орчин, урам зориг, хүсэл эрмэлзлэлийг бий болгоход чиглэгдсэн хөдөлмөрийн харилцаан дахь урамшуулал, идэвхжүүлэлтийн аргад тулгуурласан олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн 2018-2024 он хүртэл хэрэгжүүлэх “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа” аймгийн хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг эхлүүлээд байна.



Хоёр.Салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн:

Аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 6 арга хэмжээний хүрээнд 38 ажил,арга хэмжээг тусган **70.6** хувийн биелэлттэйгээр хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Гурав. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр, шийдвэрийн хэрэгжилт тооцсон байдал, хуралдааны тэмдэглэлийг албажуулсан байдал:

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь тайлант хугацаанд 5 удаа хуралдаж, 26 асуудлыг хэлэлцэж, холбогдох шийдвэрүүдийг гаргаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа. Үүнд: Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхөх, удирдах ажилтны сонгон шалгаруулалтын дүн, “Төрийн албаны тэргүүний ажилтан”-аар тодорхойлогдсон төрийн албан хаагчдын материалыг хэлэлцэж уламжлах, салбар зөвлөлд хандсан өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх, өргөдөл гомдлыг магадлан шалгасан дүгнэлтийг тус тус хэлэлцэж, 22 тогтоол гарган, төр төсвийн байгууллагад нийт 84 албан бичиг хүргүүллээ.

Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэрийн талаар хурлын тэмдэглэлийг тухай бүр хөтлөн баталгаажуулж, мэдээ, мэдээллийг аймгийн албан ёсны цахим хуудсанд байршуулан иргэдэд мэдээллэх ажлыг тогтмолжууллаа.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2018 оны хуралдааны тойм

№	Салбар зөвлөлийн хуралдаан	Хуралдаан болсон огноо	Хэлэлцсэн асуудлын тухай	Шийдвэрлэлт
1	Төрийн	2018.01.25	1.2018 оныг “Хүний	1. 2018 оныг “Хүний нөөцийн



	албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №01		нөөцийн удирдлагыг хэрэгжүүлж, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарлах тухай 2.Зарласан жилийн төлөвлөгөөг батлах тухай 3.2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай	удирдлагыг хэрэгжүүлж, хариуцлагыг сахилга, хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарлахаар тогтож Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тогтоол гарган сумдын Засаг даргын Тамгын газар, хэлтэс агентлагуудад хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахаар тогтов. 2.Салбар зөвлөлийн гишүүдийн саналыг тусган нийт 6 арга хэмжээний хүрээнд 38 ажил, арга хэмжээний төслийг батлахаар тогтов.
2	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №02	2018.03.06	1.Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд ирүүлсэн өргөдлийн тухай а/Сүхбаатар сумын иргэн Н.Гантуяагийн өргөдлийг шалгасан ажлын хэсгийн дүгнэлтийн тухай б/Сүхбаатар сумын Мэргэжлийн хяналтын газрын улсын хяналтын байцаагч Н.Оюундарийн өргөдөл в/Сүхбаатар сумын Хөдөө аж ахуйн тасгийн малын эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн М.Гантуяагийн өргөдөл г/Ерөө сумын Ц.Уртнасан нарын 4 иргэний өргөдөл д/Орхонтуул сумын Рашаант тосгоны байцаагч Ч.Байгалмаагийн өргөдөл 2.”Төрийн албаны	а/Сүхбаатар сумын иргэн Н.Гантуяад ТАЗСЗ-ийн албан бичгээр хариуг хүргүүлж, өмнөх албан тушаалд нь эгүүлэн томилохоор тогтов. б/Сүхбаатар сумын Мэргэжлийн хяналтын газрын улсын хяналтын байцаагч Н.Оюундарийн өргөдлийн дагуу ажлын хэсэг томилон ажиллуулахаар болов. в/ Сүхбаатар сумын Хөдөө аж ахуйн тасгийн малын эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн М.Гантуяагийн өргөдлийн дагуу ажлын хэсэг томилон ажиллуулахаар болов. г/Ерөө сумын Ц.Уртнасан нарын 4 иргэний өргөдлийн дагуу ажлын хэсэг томилон ажиллуулахаар болов. д/Орхонтуул сумын Рашаант тосгоны Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байцаагч Ч.Байгалмаагийн өргөдлийн



			<p>тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнуулах тухай</p> <p>а/Нийгмийн даатгалын хэлтсийн дарга С.Отгонжаргал б/Шаамар сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Ш.Цогтбаатар</p> <p>в/Сант сумын ЗДТГ-ын дарга А.Одхүү г/Цагдаагийн газрын ахмад ажилтан Л.Тунгалаг</p> <p>3.Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол, хүнсний хяналтын хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшүүлэхээр ирүүлсэн материалыг хэлэлцэх тухай</p> <p>а/Тариалан ургамлын үр хорио цээрийн хяналтын улсын байцаагч А.Бямбадорж б/Мал үржлийн хяналтын улсын байцаагч Ү.Цэндсүрэн</p>	<p>дагуу ажлыг хэсэг томилон ажиллуулахаар болов.</p> <p>2.Төрийн албаны тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнуулахаар тодорхойлсон Нийгмийн даатгалын хэлтсийн дарга С.Отгонжаргал, Шаамар сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Ш.Цогтбаатар, Сант сумын ЗДТГ-ын дарга А.Одхүү, Цагдаагийн газрын ахмад ажилтан Л.Тунгалаг нарын шагналын баримт бичгийн бүрдлийг ханган Төрийн албаны зөвлөлд уламжилахаар тогтов.</p> <p>3.Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол, хүнсний хяналтын хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшүүлэхээр ирүүлсэн Тариалан ургамлын үр хорио цээрийн хяналтын улсын байцаагч А.Бямбадорж, Мал үржлийн хяналтын улсын байцаагч Ү.Цэндсүрэн нарын баталгаажсан ажлын байрны тодорхойлолт, нэр дэвшүүлэх болсон хамт олны хурлын тэмдэглэлийг ирүүлэх албан тоотыг хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>
3	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №03	2018.04.04	<p>1.Төрийн албаны зөвлөлийн зөвлөлд ирүүлсэн өргөдлийн тухай</p> <p>а/Цагааннуур сумын иргэн Б.Ганхуягаас ирүүлсэн өргөдлийн</p>	<p>а/Цагааннуур сумын ЗДТГ-ын дарга Н.Цэдэндамбад ТАЗСЗ-ийн албан бичгээр өргөдлийг шилжүүлэхээр болов.</p> <p>б/ Орхонтуул сумын Рашаант тосгоны Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байцаагч</p>



			<p>тухай б/Орхонтуул сумын Рашаант тосгоны байцаагч Ч.Байгалмаагийн өргөдлийг шалгасан ажлын хэсгийн дүгнэлтийн тухай в/Ерөө сумын Газрын даамал Ариунбаттай холбоотой өргөдлийг шалгасан ажлын хэсгийн дүгнэлтийн тухай 2.Төрийн албаны мэргэшлийн шалгалтын нөөцөөс нөхөх арга хэмжээнд материал ирүүлсэн иргэдийн тухай а/Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын Барилга угсралт, техникийн хяналт хариуцсан мэргэжилтний албан тушаалд Лхагвасүрэнгийн Мөнх-Од б/Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Хүрээлэн буй орчны бохирдол, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, химийн бодисын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Жаргалын Нямцэцэг в/Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн мал зүйчийн</p>	<p>Ч.Байгалмаагийн өргөдлийн харьяалалын дагуу ажлын хэсэг томилогдон ажиллахаар тогтов. в/ Ерөө сумын Газрын даамал Э.Ариунбаттай холбоотой өргөдлийг хариуг ТАЗСЗ-ийн албан бичгээр хариуг хүргүүлэхээр болов. 2.Төрийн захиргааны албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхөх арга хэмжээний дагуу Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын Барилга угсралт, техникийн хяналт хариуцсан мэргэжилтний албан тушаалд Лхагвасүрэнгийн Мөнх-Од, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Хүрээлэн буй орчны бохирдол, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, химийн бодисын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Жаргалын Нямцэцэг, Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн мал зүйчийн албан тушаалд Базарсадын Бямбаа, Орхонтуул сумын Газар зохион байгуулагчийн албан тушаалд Хишигмаагийн Болортуяа, Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн малын эмчийн албан тушаалд Батчулууны Бямба-Очир, Баянгол сумын Засаг даргын</p>
--	--	--	--	---



			<p>албан тушаалд Жамбаагийн Өлзийбат, Базарсадын Бямбаа г/Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль хамгаалагчийн албан тушаалд Эрдэнэбатын Ариунчимэг д/Орхонтуул сумын Газар зохион байгуулагчийн албан тушаалд Хишигмаагийн Болортуяа е/Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн мал эмчийн албан тушаалд Батчулууны Бямба-Очир ё/Баянгол сумын Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд Ганболдын Итгэл</p>	<p>Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд Ганболдын Итгэл нарын материалыг хэлэлцүүлэн албан тушаалын шаардлага хангаж байгаа 6 иргэнийг нэр дэвшүүлэхээр тогтов.</p> <p>Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль хамгаалагчийн албан тушаалд Эрдэнэбатын Ариунчимэг нөөцөөс нөхөх арга хэмжээний хугацаа дууссаны дараа материалаа ирүүлсэн, Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн мал зүйчийн албан тушаалд Жамбаагийн Өлзийбат нь Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцээгүй байсан тул 2 иргэний материалыг буцаан хүргүүлэхээр болов.</p>
4	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №04	2018.04.16	<p>1.Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтын дүнг хэлэлцэх тухай</p> <p>а/Сүхбаатар сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд Тамирын Пүрэвсүрэн б/Сүхбаатар сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд Лувсанбаатарын Наранжаргал в/Хушаат сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд</p>	<p>1.Сүхбаатар сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд Тамирын Пүрэвсүрэн, Хушаат сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд Жамьяндэвийн Алтанцэцэг, Зүүнбүрэн сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд Жандалсүрэнгийн Нямсүрэн, Сайхан сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд Энхболдын Батмөнх нарыг нэр дэвшүүлэхээр тогтов.</p> <p>Сүхбаатар сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан</p>



			Жамьяндэвийн Алтанцэцэг г/Зүүнбүрэн сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд Жандалсүрэнгийн Нямсүрэн д/Сайхан сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд Энхболдын Батмөнх	тушаалд Лувсанбаатарын Наранжаргалыг нөөцөд бүртгэхээр тогтов.
5	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №05	2018.05.25	1.Хүдэр сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын дүнг хэлэлцэх тухай а/Ганхуягийн Цэрэндамба б/Лхаасүрэнгийн Баяржавхлан в/Гантөмөрийн Ганчимэг	1.Хүдэр сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд Ганхуягийн Цэрэндамбыг нэр дэвшүүлэхээр болж, Лхаасүрэнгийн Баяржавхлан, Гантөмөрийн Ганчимэг нарыг нөөцөд бүртгэхээр тогтов.

Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн сан бүрдүүлж, түүгээр үйлчилсэн байдал, үр дүн:

Төрийн жинхэнэ албан тушаалын нөөцийн санд бүртгэлтэй байгаа иргэдийн хүсэлтээр төрийн жинхэнэ албан тушаалд томилогдох нийт 12 иргэнд төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэдийн нөөцөд бүртгэлтэй байгаа тухай Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тодорхойлолт гаргаж өгсөн байна.

Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн сангийн судалгаа:

№	Шалгалт болсон огноо	Сул ажлын байрны тоо	Тэнцсэн хүний тоо	1-ээр гарсан хүний тоо	Нөөцөөс нөхсөн	Шилжүүлсэн	Нөөцөд бүртгэлтэй хүний тоо
1	2016.12.08	27	96	14	1	24	57
2	2017.10.06	32	93	18	5	16	54
3	2018.05.04	48	36	20	1	3	13
Нийт дүн		107	225	52	5	31	124

Төсвийн шууд захирагч, менежер, төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх ажлыг мэргэшлийн удирдлагаар хангаж, үр дүнг тооцсон байдал:

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан төсвийн шууд захирагчийн, менежерийн, төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах заавар, төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журмын дагуу гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, үнэлэх явцад мэргэшил, арга зүйн удирдлагаар хангаж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.

Аймгийн Засаг даргаас агентлагийн дарга нартай байгуулсан 2017 оны үр дүнгийн гэрээний хэрэгжилтийн үнэлгээгээр “А” буюу “**маш сайн**” үнэлгээтэй 20, “В” буюу “**сайн**” үнэлгээтэй 1, дунджаар **93.3** хувийн хэрэгжилттэй дүгнэгдсэн бол аймгийн Засаг даргаас сумын Засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн үнэлгээгээр **64.6-78.0** хувийн гүйцэтгэлтэй буюу дундаж үнэлгээ нь **70.5** хувьтай үнэлэгдсэн.



Сэлэнгэ аймгийн удирдах ажилтны зөвлөгөөнийг 2018 оны 02-р сарын 06-ны өдрүүдэд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс албад, сумдын Засаг дарга, ОНӨААТҮГ-ын удирдлагууд, ойн ангийн дарга, нийгмийн салбарын үйлчилгээний байгууллагын дарга, сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарыг хамруулан өргөн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга буюу төсвийн шууд захирагчийн 2017 оны үр дүнгийн гэрээгээр нийт ажил үйлчилгээ 129, тусгай захиалгат ажил үйлчилгээ 17, манлайллын 6 зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжилтийг ханган ажилласныг аймгийн Засаг дарга буюу Төсвийн ерөнхийлөн захирагчаас гэрээний биелэлтийг **92.6** хувьтай “**маш сайн**” гэж үнэллээ.

Төсвийн шууд захирагчийн шийдвэрээр төрийн албан хаагчид өөрийн харьяалах нэгжийн менежертэй үр дүнгийн гэрээ байгуулан түүний хэрэгжилтэд улирал бүр хяналт тавьж хагас, бүтэн жилээр Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнгийн гэрээний үнэлгээнд санал дүгнэлт өгдөг ажлыг хэвшүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоох болсонтой холбогдуулан 2017 оны төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээний биелэлт, үйл ажиллагаа мэргэшлийн түвшний үнэлгээгээр хангалттай үнэлгээ авсан ахлах, дэс, туслах түшмэлийн ангиллын 97 төрийн захиргааны албан хаагчдын материалыг нэгтгэн боловсруулсан боловч одоогоор шийдвэрлээгүй байна.



**Төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэв олгосон байдлыг
сүүлийн 10 жилийн байдлаар үзүүлбэл:**

Төрийн захиргааны албан тушаалын ангилал	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
Ахлах тшмэл	7	3	6	6	3	2	10	5	7	7
Дэс түшмэл	23	25	42	43	62	48	60	39	69	53
Туслах түшмэл	21	11	22	20	25	37	27	40	23	50
Нийт дүн	51	39	70	69	90	88	97	84	99	110

**Ёс зүйн хороог арга зүйн удирдлагаар хангаж Төрийн албан хаагчийн ёс зүйн
хэм хэмжээг сахиулах асуудлаар зөвлөгөө өгч, ажилласан байдал, үр дүн:**

Аймгийн хэмжээнд аймаг, сумдын Засаг даргын Тамгын газарт 13, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлагуудад 12, нийт 25 ёс зүйн хороо томилогдон ажиллаж байна.

2018 оны хагас жилийн /урьдчилсан/ байдлаар аймаг, сум, агентлагийн нийт 11 төрийн албан хаагчдад ёс зүйн зөрчлийн дагуу арга хэмжээ авч ажилласан дүнтэй байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн хорооноос Зүүнбүрэн, Түшиг, Шаамар, Ерөө, Алтанбулаг сумын төр, төсвийн байгууллагуудад ажиллаж буй төрийн албан хаагчдад ёс зүйн талаар сургалт зохион байгуулж, арга зүйн заавар зөвлөмж өгч ажилласан.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны А/34 дүгээр тушаалаар Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ажлын сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор “Ёс зүйн зөрчилгүй хамт олон” аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулсан. Төрийн албаны болон төрийн албан хаагчтай холбоотой хууль тогтоомж, стандартыг мөрдөж, ёс зүйн хэм хэмжээг сахин ажиллаж байна.

**Өргөдөл, гомдол, маргаан, ёс зүйн зөрчлийн шийдвэрлэлт, үр дүн, түүний
мэдээг хагас бүтэн жилээр ирүүлсэн байдал:**

Аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд Төрийн албатай холбоотой асуудлаар 16 төрийн албан хаагчийн өргөдөл, гомдол ирснийг бүртгэн холбогдох хууль, журмын дагуу тухай бүр нь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүдээр ахлуулсан ажлын хэсэг томилон дүгнэлт гаргуулж, салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн хуулийн хугацаанд нь шийдвэрлэж ажиллалаа.



Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хандсан
 өргөдөл гомдлын шийдвэрлэлт:

№	Өргөдөл гаргагчийн нэр	Өргөдлийн утга	Шийдвэрлэсэн байдал
1	Ч.Байгалмаа	Сахилгын шийтгэлээ хүлээн зөвшөөрөхгүй байгаа тухай	Орхонтуул сумын Рашаант тосгоны Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байцаагч Ч.Байгалмаад ТАЗСЗ-ийн 2018 оны 48 дугаар албан бичгээр хариуг хүргүүлсэн.
2	Б.Бямбадорж	Ажилд орох тухай	Цагааннуур сумын иргэн Б.Бямбадоржид Малын эрүүл мэнд, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтний сул орон тоон дээр тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан тул Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газарт ТАЗСЗ-ийн 2018 оны 09 дүгээр албан бичгээр томилох саналыг хүргүүлсэн.
3	Л.Байгалмаа	Тушаал шалгуулах тухай	Сүхбаатар сумын иргэн Л.Байгалмаад ТАЗСЗ-ийн 2018 оны 30 дугаар албан бичгээр Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх талаар хариуг хүргүүлсэн.
4	Н.Гантуяа	Албан тушаал, цалингийн шатлал бууруулсан тухай	Сүхбаатар сумын иргэн Н.Гантуяад ТАЗСЗ-ийн 2018 оны 33 дугаар албан бичгээр хариуг хүргүүлж, өмнөх албан тушаалд нь эгүүлэн томилсон.
5	П.Ганзул	Ажилд орох тухай	Тухайн албан тушаалд мэргэжил нь таарахгүй болохыг мэдэгдсэн.
6	Б.Дашдэлэг	Ажилд авахгүй байгаа тухай	Ерөө сумын иргэн Б.Дашдэлэгд ТАЗСЗ-ийн 2018 оны 29 дүгээр албан бичгээр хариуг хүргүүлж мэргэжил нь тухайн албан тушаалд тавигдах шаардлага хангахгүй байгаа талаар мэдэгдсэн.
7	Р.Лхагвадорж	Төрийн албан хаагчийн ёс зүйн байдлын талаар	Хүдэр сумын иргэн Р.Лхагвадорж өргөдлөө буцаах хүсэлт гаргасан.
8	Ц.Уртнасан нарын 4 иргэн	Үндэслэлгүй албан бичиг явуулсан талаар	Ерөө сумын Ц.Уртнасан нарын 4 иргэн өргөдлөө буцаах тухай хүсэлт гаргасан.
9	Н.Оюундарь	Ажлын байр сэлгэн ажиллуулах болсон тухай	Сүхбаатар сумын иргэн Н.Оюундарьд ТАЗСЗ-ийн 2018 оны 60 дугаар албан бичгээр хариуг хүргүүлсэн.
10	Б.Ганхуяг	Төрийн албан хаагчийн ёс зүйн талаар	Цагааннуур сумын ЗДТГ-ын дарга Н.Цэдэндамбад ТАЗСЗ-ийн 2018 оны 47 дугаар албан бичгээр өргөдлийг шилжүүлж, өргөдөлд холбогдох төрийн

			албан хаагчид Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ авсан.
11	Б.Алтанцэцэг	Шийдвэр шалгуулах тухай	Шаамар сумын иргэн Б.Алтанцэцэгийн өргөдлийг шалгаж, хариуг хүргүүлсэн.
12	Н.Хишиг	Цалингийн ангилал, зэрэглэлийн тухай	Сүхбаатар сумын иргэн Н.Хишигт ТАЗСЗ-ийн 2018 оны 56 дугаар албан бичгээр хариуг хүргүүлж, цалинг нэмэгдүүлэх боломжгүй талаар мэдэгдсэн.
13	Ц.Болормаа	Гэр бүлийн хүмүүс төрийн албанд цуг ажиллаж байгаа талаар	Алтанбулаг сумын иргэн Ц. Болормаад ТАЗСЗ-ийн 2018 оны 76 дугаар албан бичгээр хариуг хүргүүлсэн.
14	С.Эрдэнэтуяа	Төрийн албаны мэргэшлийн шалгалттай холбоотой ажлын байрны байршлын тухай	Төрийн албаны мэргэшлийн шалгалт өгсөн ажлын байрны байршлын талаарх мэдээллийг иргэн С.Эрдэнэтуяад өгсөн.
15	Ц.Болормаа	Өргөдлийн хуулбар гаргуулах тухай	Өргөдлийг хуулбарлан иргэн Ц.Болормаад өгсөн.
16	У.Энхбат	Ажлаас чөлөөлөгдсөн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа тухай	Төрийн албаны зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу хүлээгдэж байгаа.

Салбар зөвлөлийн үйл ажиллагааны нээлттэй байдал, үйл ажиллагааг сурталчилсан байдал, үр дүн:

Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд төрийн байгууллагаас хийж хэрэгжүүлж буй ажил арга хэмжээг аймгийн **“www.selenge.gov.mn”** цахим хуудсанд байршуулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын сар тутмын **“100 нүүрт Өргөн Сэлэнгэ”** сэтгүүлээр дамжуулж иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулж байна. Сэтгүүлийн дугаар бүрт төрийн үйлчилгээний үйл ажиллагааны талаар иргэдээс мэдээлэл авах утас, хаяг, хариу мэдээллийг тогтмол нийтэлж 17 сум, 6 тосгонд тухай бүр хуваарилан иргэдэд түргэн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулж хэвшлээ.



Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн мэдээллийн самбарт Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, Салбар зөвлөлийн шийдвэр, цаг үеийн мэдээ, мэдээлэл, төрийн албан хаагчдын тоо бүртгэлийн талаар болон хийж хэрэгжүүлж буй ажил арга хэмжээний мэдээллийг байршуулж сурталчлах ажлыг тогмолжуулаад байна.



Мөн төвийн “Зууны мэдээ” сонин, Монголын үндэсний болон TV-9 телевиз орон нутгийн, “Сэлэнгийн мэдээ”, “Шинэ гэгээ” сонин “Миний Монгол” кабелийн телевиз, зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс явуулж буй цаг үеийн ажил арга хэмжээний талаар ярилцлага өгч, нийтэд мэдээллэх ажлыг зохион байгуулсан.

Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас иргэдэд мэдээ, мэдээллийг цаг алдалгүй шуурхай хүргэх, төрийн байгууллагуудын иргэдэд үзүүлж буй үйлчилгээний талаарх бүхий л мэдээллийг багтаасан, санал, өргөдөл, гомдлоо төрийн байгууллагуудад цахимаар гаргах боломж бүхий ухаалаг утсанд зориулсан “Нээлттэй Сэлэнгэ” аппликэйшнаар дамжуулан төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг иргэдэд шуурхай хүргэж, төрийн албан хаагчтай холбоотой өргөдөл гомдлыг хүлээн авч байна.



Төрийн албан хаагчийн тайлан мэдээ ирүүлсэн байдал:

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс аймгийн хэмжээний төр, төсвийн байгууллагын нийт төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг суурилагдсан программын дагуу хийх заавар зөвлөмжийн талаар холбогдох ажилтнуудад сургалт зохион байгуулж, тоо бүртгэл явуулах хуваарь гарган ажилласнаар төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг хугацаанд нь чанартай сайн хийж гүйцэтгэн аймгийн хэмжээнд 6050 /бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлангийн 2017 оны дүнгээр/ төрийн албан хаагчийн бүртгэл бүхий нэгдсэн мэдээллийн сан бүрдүүллээ. Аймагт үйл ажиллагаа явуулж буй аймгийн Гаалийн газрын 154, Цагдаагийн газрын 276 төрийн албан хаагчийн мэдээлэл харьяалах дээд шатны байгууллагадаа нэгтгэгдсэн болно.

Мэдээллийн санг ашиглан төрийн албан хаагчдад шаардлагатай төрийн албан хаагчийн биеийн байцаалт, бусад холбогдох шаардлагатай тоо баримт, мэдээллээр хангаж ажиллаж байна.

Төрийн албаны салбар зөвлөлийн самбарын мэдээллийн хэсэгт аймгийн хэмжээний төрийн албан хаагчдын тоон мэдээллийг төрийн албаны ангилал, нас, боловсрол, хүйсийн байдлаар графикаар дүрслэн байршуулж мэдээллээ.

2017 оны “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээ”-г хүний нөөцийн шинэ системээр авах болсонтой холбогдуулан мэдээллийн программ хангамжийн талаар төр, төсвийн нийт байгууллагуудын дотоод ажил, хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтнуудад заавар зөвлөгөө өгч мэргэшил арга зүйн удирдлагаар хангасан.

Салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх асуудлаар хэрэгжүүлсэн шинэлэг ажил, үр дүн:

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 2018 оны 1 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог, Б.Нарантуяа, Хяналт-шинжилгээ,

үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Д.Лувсандагва, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга М.Нарантуяа нараар ахлуулсан 4 ажлын хэсэг нийт 8 сум, 8 агентлагт зөвлөн туслах, хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулж, ажлын хэсгийн дүгнэлтүүдийг аймгийн удирдлагуудад танилцуулсан.

2018 оны Засгийн газрын “Хариуцлагын жил”, аймгийн “Хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх жил”, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлж, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх жил”, аймгийн ЗДТГ-ын “Шинэ санал, санаачлагыг дэмжих жил”-ийн зорилтуудыг хэрэгжүүлж, аймгийн Засаг даргын захирамжаар “Удирдах ажилтны мэдээллийн цаг” арга хэмжээний хуваарь оролцох байгууллагуудыг баталгаажуулан 4 удаа зохион байгуулсан. Тус арга хэмжээгээр байгууллагын удирдлагууд цаг үеийн ажил байдлын талаар мэдээлэл бэлтгэж, аймгийн удирдлагуудаас байгууллагын дарга нарт салбарын хэмжээнд хууль, журам, заавар, төрийн албаны стандартын хэрэгжилтийн талаар тухай бүр үүрэг чиглэл өгч, үр дүнг тооцож байна.



Хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэстэй хамтран Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд дотоод аудит оруулах ажлыг зохион байгуулж байна.

“Орон нутгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтнуудын чадавхийг сайжруулах нь” сэдэвт сургалтыг 2018 оны 6 дугаар сарын 18-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын Хэрэг Эрхлэх газар, Удирдлагын академи, Хувь хүний хөгжлийн институттай хамтран аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн хяналт-шинжилгээ, үнэлгээний чиг үүргийг хариуцсан ажилтнууд, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, Тосгодын захирагч нар нийт 60 гаруй хүнийг хамруулсан. Тус сургалтаар аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга Ө.Сувдаа “Нутгийн захиргааны байгууллагын бодлого төлөвлөлт, хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд” сэдвээр оролцогчдод илтгэл тавьж хэлэлцүүлэг хийсэн. Мөн тус сургалттай хамтатган 2017 оны үйл ажиллагааны үр дүнгээр аймагт



тэргүүлсэн Хүдэр сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаатай сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарыг туршлага судлах ажлыг зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/458 тоот захирамжаар “Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хугацаатай тайлан мэдээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-д тусгасан Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудад дунджаар 84.0 хувь, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилт дунджаар 78.0 хувь, Хүний нөөцийн бодлого төлөвлөлт дунджаар 79.0 хувийн биелэлттэйгээр дүгнэгдсэн бол сумын Засаг даргын Тамгын газар Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт дунджаар 72.8 хувь, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилт дунджаар 72.8 хувь, Хүний нөөцийн бодлого төлөвлөлт дунджаар 79.0 хувьтай байна.

Салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар олон нийтийн /иргэдийн/ үнэлгээ:

Аймгийн Засаг даргын 2017 оны А/458 тоот захирамжаар батлагдсан “Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хугацаатай тайлан мэдээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-аар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газрын төрийн үйлчилгээний чанар хүртээмж, нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа, мэдлэг чадвар, болон төр засгаас баримтлаж буй бодлого шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлж буй байдалд иргэдийн санал дүгнэлтийг авах, хэрэглэгчийн үнэлгээг тодорхойлохоор шийдвэрлэсэн.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 302 дугаар тушаалаар батлагдсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийг хэрэгжүүлж, “Үйлдвэрчний эвлэлийн холбоо”-той хамтран аймгийн хэмжээнд Хэрэглэгчийн үнэлгээг тооцох ажлыг зохион байгуулсан. Хэрэглэгчийн үнэлгээнд нийт 600 иргэнийг хамруулж, хэрэглэгчийн үнэлгээний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цаашид хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг сайжруулах, бодитой гаргах үүднээс, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллахаар чиглэл баримтлан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт зорилт, арга хэмжээг тусган иргэдийн оролцоог бүх талаар ханган ажиллаж байна.

Салбар зөвлөлийн хагас, бүтэн жилийн тайлан ирүүлсэн байдал:

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2018 оны хагас жилийн үйл ажиллагааны тайланг Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 126 дугаар тогтоолоор батлагдсан **“Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажил дүгнэх 20 үзүүлэлт”**-ийн дагуу боловсруулж хугацаанд нь хүргүүлсэн.



Хорь. Төрийн албаны зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлт:

Тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлөөс судалгаа, тайлбар ирүүлэх тухай хугацаатай 7, салбар зөвлөлийн чиг үүрэгтэй холбоотой тогтоол, заавар, зөвлөмж 1 ирснийг бүртгэн холбогдох арга хэмжээг авч, хугацаанд нь тайлагнах ажлыг зохион байгууллаа.

Төрийн албаны зөвлөлөөс 2018 онд ирсэн албан бичгийн шийдвэрлэлт:

№	Огноо	Дугаар	Хаанаас ирсэн	Бичгийн утга	Хэрэгжилт
Хугацаатай тайлан мэдээний тухай					
1	2018.02.06	136	Төрийн албаны зөвлөл	Хууль тогтоомж хэрэгжүүлэх тухай	Сумдын Засаг дарга, хэлтэс, агентлагийн дарга нарт хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар ТАЗСЗ-ийн 2018 оны 24 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.
2	2018.02.13	161	Төрийн албаны зөвлөл	Өргөдөл шилжүүлэх тухай	ТАЗСЗ-ийн 2018 оны 25 дугаар албаг бичгээр иргэний өргөдлийн хариуг хүргүүлсэн.
3	2018.04.10	324	Төрийн албаны зөвлөл	Материал хүргүүлэх тухай	ТАЗСЗ-ийн 2018 оны 65 дугаар албан тоотоор Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт материалыг хүргүүлсэн
4	2018.05.11	480	Төрийн албаны зөвлөл	Салбар зөвлөлүүдийн 2017 оны үйл ажиллагааг үнэлсэн тухай	Үйл ажиллагаандаа тусгаж ажилласан.
	2018.05.25	545	Төрийн албаны зөвлөл	Гомдол шилжүүлэх тухай	ТАЗСЗ-ийн 2018 оны 85 дугаар албан бичгээр хариуг хүргүүлсэн
5	2018.05.30	569	Төрийн албаны зөвлөл	Судалгаа авах тухай	Албан хаагчдын судалгааг 2018 оны бдугаар сарын 6-ны өдөр info@csc.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн.
6	2018.06.08	613	Төрийн албаны зөвлөл	Материал ирүүлэх тухай	С.Алтаннур, Р.Батзаяа нарын төрийн албаны мэргэшлийн шалгалтын материалыг ТАЗСЗ-



					ийн 2018 оны 82 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
7	2018.06.20	687	Төрийн албаны зөвлөл	Тайлан мэдээ ирүүлэх тухай	Тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлсэн.
Тогтоол, заавар, зөвлөмжийн талаар:					
1	2018.05.30	570	Төрийн албаны зөвлөл	Тогтоол хүргүүлэх тухай	Холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ